“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2022 оны 05 сарын 20 өдөр    Дугаар 05    Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хурлын 03 дугаар тэмдэглэлд:

**<u>ХЭЛЭЛЦСЭН нь:</u>**

2021 оны дотоод хяналтын ажлын тайлан

**СОНССОН нь:**
Дотоод хяналтын албаны 2021 онд хийсэн ажлын тайланг танилцуулав.

**<u>ШИЙДВЭРЛЭСЭН нь:</u>**

Дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээ авч ажиллахыг компанийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт даалгав:

1.Компанийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлээс сэргийлэх чиглэлээр дотоод хяналтыг зохион байгуулах;

2.Дотоод хяналтын журам, эрх зүйн актыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсронгуй болгох;

3.Дотоод хяналтын тайланд тогтоогдсон нөхцөл байдал, зөрчлийн талаар хууль зүйн үндэслэлтэй тусгах, тайлангийн боловсруулалтыг сайжруулах;

4.Дотоод хяналтын албаны тайланг хагас жил тутамд Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанд танилцуулах.

ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ДОРНОД БҮСИЙН ТТР0374 ☎ 2628651 ДОРНОД АЙМАГ

ДАРГА Ж.ЖАНАРБААТАР

58002205

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 20 өдөр Дугаар 14 Хэрлэн сум

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг
арилгах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дүрмийн 7.3.17 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийг мөрдөж ажиллаагүй нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шалгалтаар тогтоогдсон холбогдох албан хаагчдад хууль тогтоомжид нийцүүлэн сахилгын шийтгэл ногдуулах, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт үүрэг болгосугай.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Э.Эрдэнэхишиг/-нд даалгасугай.

ДАРГА Ж.ЖАНАРБААТАР

ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ДОРНОД БҮСИЙН ДОРНОД АЙМАГ

580222021

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 20 өдөр Дугаар 15 Хэрлэн сум

Авлигын эсрэг үйл ажиллагааны тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дүрмийн 7.3.17 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалд тусгасан шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж, ажиллахыг гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт үүрэг болгосугай.

2. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг стандартын дагуу боловсруулж тайлагнахыг Гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар, эрх бүхий албан тушаалтан (А.Мэндсайхан) нарт даалгасугай.

ДАРГА Ж.ЖАНАРБААТАР

580222018

"ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ"
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 20 өдөр Дугаар 16 Хэрлэн сум

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2, 31.3.1, 31.3.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.2, 1.4, 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон, хавсралтад заасан 54 нэр төрлийн 677,444,281.21 /Зургаан зуун далан долоон сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга хоёр зуун наян нэгэн төгрөг хорин нэгэн мөнгө/ төгрөгийн балансын үнэтэй үндсэн хөрөнгийг бүртгэлээс хасах саналыг дэмжсүгэй.

2. Үндсэн хөрөнгө данснаас хасах асуудлыг Эрчим хүчний яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулж ажиллахыг гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт даалгасугай.

ДАРГА Ж.ЖАНАРБААТАР

ЭРЧИМ ХҮЧНИЙ
ДОРНОД БҮСИЙН
СИСТЕМ ТӨХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ТТР0374 ш 2628651
ДОРНОД АЙМАГ

580222019

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2022 оны 05 дугаар сарын ..-ний
өдрийн ... дугаар тогтоолын
хавсралт

## Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

| Д/д | Хөрөнгийн нэр, марк | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Ашиглалтад орсон огноо | Балансын | | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Нэгжийн үнэ | Нийт өртөг | | |
| 1 | **Тоног төхөөрөмж** | | | | | | | |
| 1.01 | Таазны бетон Зуух №1 ТП-35 | ширхэг | 1 | 2002-01-01 | 38,103,638 | 38,103,638.03 | 38,103,638.03 | - |
| 1.02 | Топканы зүүн хажуу ханаы зангилаа өрлөг Зуух №1 ТП-35 | ширхэг | 1 | 2002-01-01 | 21,662,258 | 21,662,258.00 | 21,662,258.00 | - |
| 1.03 | Топканы нүүрний ханаы өрлөг Зуух №1 ТП-35 | ширхэг | 2 | 1980-01-01 | 70,974 | 141,947.00 | 141,947.00 | - |
| 1.04 | Топканы баруун хажуу ханаы өрлөг Зуух №1 ТП-35 | ширхэг | 1 | 2002-01-01 | 21,662,258 | 21,662,258.00 | 21,662,258.00 | - |
| 1.05 | Нүүрний доод хэсгийн коллектор Зуух №1 ТП-35 | ширхэг | 1 | 2002-01-01 | 32,493,377 | 32,493,377.00 | 32,493,377.00 | - |
| 1.06 | Агаар халаагчийн 2-р үе Зуух №2 ТП-35 | ширхэг | 1 | 1999-01-01 | 104,959,599 | 104,959,599.00 | 104,959,599.00 | - |
| 1.07 | Тогоо / барабан / Зуух №1 ТП-35 | ширхэг | 1 | 2002-01-01 | 217,437,373 | 217,437,373.00 | 217,437,373.00 | - |
| 1.08 | Түүхий нүүрсний бункер | ширхэг | 2 | 1969-01-01 | 147,303 | 294,605.00 | 294,605.00 | - |
| 1.09 | Радио станц | ширхэг | 3 | 2008-01-01 | 212,869 | 638,607.00 | 638,607.00 | - |
| 1.10 | Радио станцын зай | ширхэг | 3 | 2008-01-01 | 37,059 | 111,177.00 | 111,177.00 | - |
| 1.11 | Паносоник КХ-ТД500 тоон станц | ширхэг | 1 | 2003-12-31 | 67,173,492 | 67,173,492.00 | 67,173,492.00 | - |
| 1.12 | Амперметр Э-514 | ширхэг | 2 | 1969-12-31 | 1,237 | 2,474.00 | 2,474.00 | - |
| 1.13 | КРУ-6кв I II секцТаслуур тосон 37 ячейк ВМП-10-1500 | ширхэг | 1 | 2003-01-01 | 16,616,845 | 16,616,844.66 | 16,616,844.66 | - |
| 1.14 | КРУ-6кв I II секц Таслуур тосон 30 ячейк ВМП-10 | ширхэг | 1 | 2003-01-01 | 11,390,000 | 11,390,000.00 | 11,390,000.00 | - |
| 1.15 | Лабораторын нам эталон хэмжүүр | ширхэг | 1 | 2006-12-25 | 5,624,000 | 5,624,000.00 | 5,624,000.00 | - |
| 1.16 | Милливольтметр Ф-116 | ширхэг | 1 | 1969-01-01 | 694 | 694.00 | 694.00 | - |
| 1.17 | Өнгөлөгч машин 3622Д | ширхэг | 1 | 1982-01-01 | 90,011 | 90,011.00 | 90,011.00 | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.18 | Өнгөлөгч машин 3А64Д | ширхэг | 1 | 1970-01-01 | 123,240 | 123,240.00 | 123,240.00 | - |
| 1.19 | Токарийн машин TUG-40 | ширхэг | 1 | 1999-01-01 | 3,850,400 | 3,850,400.00 | 3,850,400.00 | - |
| 1.20 | Өрмийн станок | ширхэг | 1 | 1969-01-01 | 20,364 | 20,364.00 | 20,364.00 | - |
| 1.21 | Виброметр VM-3800 | ширхэг | 1 | 2010-10-31 | 4,500,000 | 4,500,000.00 | 4,500,000.00 | - |
| 1.22 | Сүхбаатар сумын 10/0.4 кВ-ын 160 кВА-ын дэд станц | ширхэг | 1 | 2010-01-01 | 26,805,600 | 26,805,600.00 | 26,805,600.00 | |
| | **Дүн** | | | | | **573,701,958.69** | **573,701,958.69** | - |
| 2 | **Тээврийн хэрэгсэл** | | | | | | | |
| 2.01 | Автокран КС 25-61 14-33ДОА | ширхэг | 1 | 2000-01-01 | 20,902,302 | 20,902,302.00 | 20,902,302.00 | - |
| 2.02 | Автобус чихган 71-00 ДОА | ширхэг | 1 | 2007-01-01 | 44,078,582 | 44,078,582.00 | 44,078,582.00 | - |
| | **Дүн** | | | | | **64,980,884.00** | **64,980,884.00** | |
| 3 | **Тавилга эх хогшил** | | | | | | | |
| 3.01 | Сандал | ширхэг | 8 | 2009-07-31 | 99,992 | 100,000 | 100,000.00 | - |
| 3.02 | Сейф | ширхэг | 1 | 2004-01-01 | 3,541 | 3,542 | 3,542.00 | - |
| 3.03 | Сандал | ширхэг | 1 | 2010-12-31 | 34,999 | 35,000 | 35,000.00 | - |
| 3.04 | Ком-ийн ширээ/шаргал/ | ширхэг | 1 | 2009-01-01 | 166,459 | 166,460 | 166,460.00 | - |
| 3.05 | Компютерийн ширээ/шаргал/ | ширхэг | 1 | 2009-01-01 | 149,989 | 149,990 | 149,990.00 | - |
| 3.06 | Шүүгээ | ширхэг | 1 | 2004-01-01 | 145,059 | 145,060 | 145,060.00 | - |
| 3.07 | Шургуулга | ширхэг | 1 | 2004-01-01 | 174,369 | 174,370 | 174,370.00 | - |
| 3.08 | Ширээ | ширхэг | 2 | 2010-10-26 | 319,998 | 320,000 | 320,000.00 | - |
| 3.09 | Компютерийн ширээ | ширхэг | 1 | 2004-01-01 | 291,589 | 291,590 | 291,590.00 | - |
| 3.10 | Холбоос | ширхэг | 1 | 2004-01-01 | 86,449 | 86,450 | 86,450.00 | - |
| 3.11 | Эйр кондишнен серверийн өрөөнд Sanyo | ком | 1 | 2011-09-30 | 4,709,208 | 4,709,209 | 4,709,209.00 | - |
| | **Дүн** | | | | | **6,181,671** | **6,181,671.00** | |
| 4 | **Компьютер , техник хэрэгсэл** | | | | | | | |
| 4.01 | Дэлгэц /ACER LED V206/ | ширхэг | 1 | 2016-01-01 | 167,482 | 167,482 | 167,482.00 | - |
| 4.02 | принтер /өнгөт LJ2600/ | ширхэг | 1 | 2008-01-01 | 480,698 | 480,698 | 480,698.00 | - |
| 4.03 | Компьютерийн процессор DELL Vostro 230 MT | ширхэг | 2 | 2012-03-31 | 506,364 | 1,012,727 | 1,012,727.25 | - |
| 4.04 | Компьютерийн дэлгэц LCD 19инч DELL | ширхэг | 1 | 2012-03-31 | 172,727 | 172,727 | 172,727.27 | - |
| 4.05 | Дэлгэц /ACER LED V206/ | ширхэг | 1 | 2016-01-01 | 167,482 | 167,482 | 167,482.00 | - |
| 4.06 | Процессор ACER DT-ATC605 | ширхэг | 1 | 2014-02-25 | 637,000 | 637,000 | 637,000.00 | - |
| 4.07 | Компьютер DELL ТЭЗҮ Зуух, Цах шит 35 ДНШ | ширхэг | 3 | 2009-12-01 | 789,000 | 2,367,000 | 2,367,000.00 | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.08 | Нетбүк DELL inspiron N5110 | ширхэг | 1 | 2012-03-31 | 1,099,091 | 1,099,091 | 1,099,091.00 | - |
| 4.09 | Компьютер сервер DELL T110 4GB | ширхэг | 1 | 2012-03-31 | 1,600,000 | 1,600,000 | 1,600,000.00 | - |
| 4.10 | Канон 2520 | ширхэг | 1 | 2014-04-30 | 3,286,136 | 3,286,136 | 3,286,136.00 | - |
| 4.11 | Компьютер HEDY pen dual core | ширхэг | 1 | 2008-01-01 | 484,036 | 484,036 | 484,036.00 | - |
| 4.12 | Скайнер /TSN415/ | ширхэг | 1 | 2016-06-01 | 140,800 | 140,800 | 140,800.00 | - |
| 4.13 | Зөөврийн компьютер /TOSHIBA X870/ | ширхэг | 1 | 2016-01-01 | 3,231,942 | 3,231,942 | 3,231,942.00 | - |
| 4.14 | Нетбүк MOGUL normadic 3400 | ширхэг | 1 | 2012-03-31 | 618,182.0 | 618,182.0 | 618,182.00 | - |
| 4.15 | Компьютер HEDY pen dual core | ширхэг | 1 | 2008-01-01 | 484,036 | 484,036 | 484,036.00 | - |
| 4.16 | Телефакс | ширхэг | 1 | 2007-01-01 | 651,240 | 651,240 | 651,240.00 | - |
| | **Дүн** | | | | | **15,982,398** | **15,982,397.52** | - |
| **5** | **Биет бус хөрөнгө** | | | | | | | |
| 5.01 | НББЕББ | шир | 1 | 2011-12-31 | 6,000,000 | 6,000,000 | 6,000,000.00 | - |
| 5.02 | Санхүүгийн програм | шир | 1 | 2011-12-31 | 6,836,870 | 6,836,870 | 6,836,870.00 | - |
| 5.03 | Даймонд програм нэмэлт | шир | 1 | 2013-10-31 | 3,760,500 | 3,760,500 | 3,760,500.00 | - |
| | **Дүн** | | | | | **16,597,370.00** | **16,597,370.00** | - |
| | **Нийт дүн** | | | | | **677,444,281.21** | **677,444,281.21** | |

-oOo-

"ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ"
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2022 оны 05 сарын 20 өдөр Дугаар 06 Хэрлэн сум

"Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хурлын 06 дугаар тэмдэглэлд:

**"ХЭЛЭЛЦСЭН нь:**

Чойбалсангийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх төслийн ажлын явцын тухай.

**СОНССОН нь:**

Чойбалсангийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх төслийн хэрэгжилтийн ажлын явц, санхүүжилтийн талаар танилцуулав.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

Чойбалсангийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх төслийн ажилд компанийн зүгээс шаардлагатай арга хэмжээ авч дэмжиж ажиллахыг гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт даалгав.

ДАРГА Ж.ЖАНАРБААТАР

ЭРЧИМ ХҮЧНИЙ
ДОРНОД БҮСИЙН
СИСТЕМ ТӨХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ
ЗӨВЛӨЛ
ТТР0374 ☎ 2628651
ДОРНОД АЙМАГ

580022006

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 20 өдөр Дугаар 17 Хэрлэн сум

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.4, 123 дугаар зүйлийн 123.1, 123.2, 123.2.2, 123.3 дахь заалт, Гүйцэтгэх захиралтай байгуулсан “Контракт”-ын 6.2 дахь заалт, Эрчим хүчний сайдын 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн а/1607 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар нь Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан контрактад заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах үүргээ биелүүлээгүй хариуцлага алдсан тул компанийн нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, хариуцлагыг сайжруулах, техникийн аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг мөрдөж ажиллахыг гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт үүрэг болгосугай.

ДАРГА Ж.ЖАНАРБААТАР

ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК-ИЙН ДОРНОД БҮСИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТР0374 ☎ 2628651 ДОРНОД АЙМАГ

580222020